



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.09.12 № 11770
танай 2024.09.04 ны № 11797 -Т

**БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА**

“Журам батлах тухай” Боловсролын сайдын
2024 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн А/64
дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн
дагуу хянан үзээд, захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн сангийн ...6913..... дугаарт
бүртгэснийг үүгээр хүргүүлж байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151603344
Doc.yam a5.2024

19

1916



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 09 сарын 12-ны
өдрийн 1922 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14 Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), сургалтыг чанартай зохион байгуулахыг багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

4.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Журам батлах тухай" 2021 оны А/71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР



14241 0259

Боловсролын сайдын 2024 оны
09 дүгээр сарын 02 ний өдрийн
А/Д дугаар тушаалын хавсралт
167

БАГШЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БОЛОН ҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

А 129 7 0116621 01 -07 -2

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь багшийн мэргэжлээс бусад мэргэжилтэй иргэнд багшлах эрх олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Багшлах эрх олгох үйл ажиллагааг нээлттэй, уян хатан, тэгш хамруулсан, суралцагчийн хэрэгцээнд нийцсэн байх зарчмыг баримтлан зохион байгуулна.

Хоёр. Багшлах эрх олгох сургалтын хэлбэр, төрөл, баримт бичиг

2.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагад ажиллах хүсэлтэй иргэнийг багшлах эрх олгох хувилбарт сургалтаар бэлтгэнэ.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан хувилбарт сургалт доор дурдсан төрөлтэй байна:

2.2.1. багшаас бусад мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн иргэнд багшлах эрх олгох сургалт;

2.2.2. багш мэргэжил эзэмшсэн иргэнд боловсролын өөр түвшний боловсролын сургалтын байгууллагад, эсхүл өөр судлагдахууны чиглэлээр багшлах эрх олгох сургалт;

2.2.3. багшаас бусад мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдад багшлах эрх олгох сургалт.

2.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад багшлах эрхийг чадамжид суурилсан сургалтаар олгоно.

2.4. Мэргэжлийн сургалтын байгууллагад багшлах эрхийг сургах зүйн чадамж эзэмшүүлэх сургалтаар олгоно.

2.5. Энэ журмын 2.1, 2.3-т заасан сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн төгсөгчид багшлах эрхийн гэрчилгээ, 2.4-д заасан сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн төгсөгчид батламж олгоно.

2.6. Багшлах эрх олгох сургалтын зохион байгуулалт нь танхимын, цахим, зайн, ажлын байранд суурилсан, хосолсон хэлбэртэй байж болно.

Гурав. Сургалтад тавигдах шаардлага

3.1. Энэхүү журмын 2.1-д заасан сургалтад хамрагдах иргэн дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1.математик болон байгалийн шинжлэх ухаан, анагаах ухаан, мэдээлэл харилцаа, технологи, хууль, бизнес, эдийн засаг, урлаг, англи хэлний чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагыг 2.7-оос доошгүй голч дүнтэй төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй байх, эсхүл эдгээр чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад 2.7-оос доошгүй голч оноотой суралцаж байгаа гурав, дөрөвдүгээр ангийн суралцагч байх;

3.1.2.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын болон бусад гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;

3.1.3.монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;

3.1.4.сэтгэцийн өвчин, эмгэггүй байх.

3.2. Багшлах эрх олгох сургалтын хөтөлбөр нь Боловсролын ерөнхий хуулийн 17.3-т заасан байгууллагын дүгнэлттэй, хүүхдийн эрх, хамгаалал, суралцахуйн онол, арга зүй, тухайн түвшний боловсролын сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх технологи, үнэлгээ зэрэг агуулгыг тусгасан байна.

3.3. Багшлах эрх олгох сургалтын багш нь боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, багш мэргэжилтэй байна.

3.4. Багшлах эрх олгох сургалтад хамрагдах хүсэлтэй иргэн доор дурдсан баримт бичгийг энэхүү журмын 4.1, 4.2-д заасан байгууллагад цахимаар бүртгүүлнэ:

3.4.1.сургалтад хамрагдах хүсэлт;

3.4.2.анкет;

3.4.3.эзэмшсэн боловсролын баримт бичгийн хуулбар;

3.4.4.3x4 хэмжээний цээж зураг;

3.4.5.журмын 3.1.2, 3.1.4-д заасан шаардлагыг хангаж байгаа тухай эрх бүхий байгууллагын тодорхойлолт.

3.5. Багшлах эрх олгох сургалтын хугацаа 45 хоногоос дээшгүй байна.

Дөрөв. Оролцогч талууд, тэдгээрийн чиг үүрэг

4.1. Энэхүү журмын 2.1, 2.3-т заасан багшлах эрх олгох сургалтыг магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна. Сургалтыг мэргэжлийн байгууллага, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

4.2. Энэхүү журмын 2.4-т заасан багшлах эрхийн сургалтыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох талуудтай хамтран зохион байгуулна.

4.3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.багшлах эрх олгох сургалт зохион байгуулах байгууллагыг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх;

4.3.2.багшлах эрх олгох сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхэд холбогдох байгууллага, талуудад дэмжлэг үзүүлэх;

4.3.3.багшлах эрх олгох сургалт зохион байгуулж буй байгууллага, талуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.3.4.багшлах эрх олгох сургалтад хамрагдаж, амжилттай төгссөн төгсөгчид энэхүү журмын 2.5-д заасан баримт бичгийг олгох, хүчингүй болгох, сэргээх, холбогдох мэдээллийн сан үүсгэх;

4.4. Энэхүү журмын 4.1-д заасан байгууллага нь багшлах эрх олгох сургалтыг зохион байгуулахтай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.4.1.багшлах эрх олгох сургалтад хамрагдах, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан иргэдийг бүртгэж, мэдээллийн сан үүсгэх;

4.4.2.гадаад, дотоодын дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн, багшаас бусад мэргэжлийн иргэдийн өмнө эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлж, дүйцүүлж, үр дүнд үндэслэн ганцаарчилсан, эсхүл бүлгийн сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.4.3.сургалтын явцад суралцагчдын үнэлгээг зохион байгуулж, мэдээллийн сан үүсгэх;

4.4.4.сургалтын үр дүнг үнэлж, баталгаажуулах;

4.4.5.багшлах эрх олгох сургалтад хамрагдаж төгссөн иргэдийн мэдээллийг баталгаажсан үр дүнгийн хамт энэхүү журмын 4.3-т заасан байгууллагад хүргүүлэх.

4.5. Багшлах эрхийн гэрчилгээ нь цахим хэлбэртэй байж болно. Иргэний хүсэлтээр багшлах эрхийн гэрчилгээг үнэт цаасаар хэвлэн олгож болно.

4.6. Багшлах эрхийн гэрчилгээг үнэт цаасаар олгохдоо албан ёсны эрхтэй хэвлэх үйлдвэрт хэвлэнэ.

4.7. Үнэт цаасаар хэвлэсэн багшлах эрхийн гэрчилгээг гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд доор дурдсан баримт бичгийг үндэслэн нөхөн олгоно:

4.7.1.багшлах эрхийн гэрчилгээ нөхөн авах тухай хүсэлт;

4.7.2.багшлах эрхийн гэрчилгээний үндсэн үнийг төлсөн төлбөрийн баримт.

4.8. Багшлах эрхийн гэрчилгээг цаасан хэлбэрээр нөхөн олгох үйл ажиллагааг иргэний хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 өдөрт багтаан зохион байгуулна.

4.9. Багшлах эрхийн гэрчилгээ нь мэдээллийн санд бүртгэлтэй дугаартай, QR кодтой байна. Гэрчилгээний дугаар нь боловсролын түвшин, тушаал батлагдсан оны сүүлийн 2 орон, тушаалын дугаар, бүртгэлийн дугаарыг тус тус илэрхийлнэ.

Тав. Бусад

5.1. Багшлах эрхийн гэрчилгээтэй иргэн нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагатай Хөдөлмөрийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан гэрээ байгуулж ажиллана.

5.2. Хувилбарт сургалтад хамрагдах болон багшлах эрхийн гэрчилгээ хэвлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн багшлах эрхийн гэрчилгээ хүссэн иргэн хариуцна.

5.3. Иргэн багшаар 5-аас дээш жил ажиллаагүй тохиолдолд багшлах эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцно.

5.4. Багш удаа дараа ёс зүйн зөрчил гаргаж, хүүхдийн эрхэд халдсан нь зохих журмын дагуу хийсэн үзлэг, шалгалтаар тогтоогдож, ёс зүйн дэд хорооны шийдвэр гарсан тохиолдолд ёс зүйн сургалтад хамрагдаж, түүнийгээ баталгаажуулах хүртэл хугацаанд багшлах эрхийн гэрчилгээг түдгэлзүүлнэ.

5.5. Журмын 5.4-д заасны дагуу ёс зүйн сургалтад хамрагдсан тохиолдолд боловсролын сургалтын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн багшлах эрхийн гэрчилгээг сэргээнэ.

5.6. Багшлах эрхийн гэрчилгээ, батламжийг хуурамчаар үйлдэж, ашиглахыг хориглоно.

---oOo---